

ЦАМ-БУРХАНЫ ШАШНЫ БАГТ БҮЖГИЙН ТУХАЙ

Г. Лхагвасүрэн - МУИС. НШУС. Шашин Судлалын тэнхим, магистрант

Түлхүүр үг: Цам, Молан тойны эхийн ачийг хариулсан гэх цам, Эмгэн өвгөн цам.

Товч утга: Буддын мэдлэг ухаан нь их тав, бага таван ухаанаас бүрддэг. Их таван ухааны дотор Урлахуй ухаан багтах бөгөөд үүнээс Дууриан бүжихүй хэмээх бага таван ухааны нэг нь салбарлан гардаг. Дууриан бүжихүйн нэг төрөл нь цам. Цам нь бурханы шашны зан үйл бөгөөд дайснаа дарж, энэ дэлхийд бурханы шашин ялсныг харуулах, мөн номлол сургаалыг нь дэлгэрүүлэх шашны багт бүжиг юм. Цамын дүрүүд нь биеэрээ бурхадын дүр байдлыг үзүүлэн цамнадаг. Энэ нь нэг талаас бурханы шашны зан үйл хэдий ч нөгөө талаас урлагийн нэг төрөл мөн. Энэтхэг, Төвдөөр дамжин Монголд цам XVIII зууны үед орж ирэхдээ авъяаслаг уран гарт ард түмний минь сэтгэмж, гоо сайхны мэдрэмжээр бүтээгдсэн өвөрмөц онцлогтой. Мөн Монголд цамд ардын үлгэр домгийн баатрууд, нутгийн шүтээнийг оруулан баяжуулж, олон янзын агуулга, дүр байдал, тавилт дэглэлтээр хөгжүүлж, олон төрлийн цамыг нутаг нутагт дэглэн тавьж байсан.

Буддизм нь Дорно дахины ард түмний оюун ухааны их ололт, дэлхийн соёлын өв юм. Эл сэтгэлгээний өвийг эдүгээ хүртэл олон зуун мянган жилийн туршид хадгалан хөгжүүлж ирэхэд Дорно дахины ард түмнүүд өөр өөрийнхөө хувь нэмрээ оруулсан байдаг. Монгол оронд Буддын шашин дэлгэрсэн цагаас Буддын мэдлэг ухааныг эзэмшсэн олон олон мэргэд төрж зохиол бүтээлээ туурвиж байсан нь бурханы шашны хөгжил дэлгэрэлтэд эерэгээр нөлөөлж, нөгөөтэйгүүр Монголын ард түмний мэдлэг, гүн ухаан, соёлын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан. Бурханы шашны өв санг хадгалан хөгжүүлэхэд дорвитой нөлөө үзүүлсэн орон бол Энэтхэг, Төвд хоёр. Монголчууд Энэтхэг болон Төвдөөс Буддын мэдлэг ухааны салбаруудыг өвлөн авч хөгжүүлсэн.

Буддын мэдлэг ухаан нь их, бага нийт арван ухаанаас бүрддэг. Их таван ухааны дотор Урлахуй ухаан гэх урлаг техникийн ухаан багтана. Энэ ухаан нь бүтээж туурвих болоод биеэр үзүүлэх урлагийн цогц ухаан байдаг. Урлахуй ухаанаас бага таван ухааны нэг Дууриан бүжихүй салбарлан гардаг бөгөөд энэ урлагийг анх Шамбалын оронд дэлгэрсэн гэж үздэг. Дууриан бүжихүйд инээд наадмын орон олон байдаг бол түүний нэгэн төрөл болох цамд инээд наадмын төдийд ч хүндэтгэлгүй хандах зүйл байдаггүй. Цам нь шашны зан үйлийн ёс бөгөөд дайсныг дарах, энэ дэлхийд Бурханы шашин ялсныг харуулах, буянаа арвижуулах улмаар Бурханы шашны номыг дэлгэрүүлэх бүжиг юм.

Цамын тухай бичсэн мэргэжлийн түвшиний ном судар зөвхөн Төвд хэлнээ байдаг. Уг ном судрыг сахил хүртээгүй хүн уншиж судлах нь хориотой байсантай холбоотойгоор ард иргэдийн дунд цамын талаарх тэдлэг ойлголт гүехэн байдаг¹. Сүүлхэн үед цам цамнах зан үйл нь орхигдсон зүйл болсон байв. Учир нь Их хүрээнд 1937он хүртэл цам гарч байсан² хэдий ч социализмын үед шашингүйн суртал нэвтрүүлэг хүчтэй болж шашны сургаал номлол, зан үйл хориотой хаалттай байсны улмаас цам цамнахаа больсон байна. Харин ардчилалын жилүүдэд шашныг нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрснөөр цамыг хуучин дэг жаягаар нь дэглэн тавих боломжтой болсон хэдий ч олон жил тасалдсан зан үйлийг сүм хийдүүд сэргээн сүсэгтэн олонд таниулахад ихээхэн хүндрэлтэй байсан юм.

¹ Гангаа.Д, Хүрээ цам УБ., 2003 2-р тал

² Мөн тэнд 18-р тал

Харин 2000-аад оноос хойш Зүүн хүрээ буюу Дашчойлин хийд жил бүр Хүрээ цамыг дэглэн тавьж байгаа нь иргэдийн дундах цамын тухай ойлголтыг жилээс жилд тэлэхэд хүргэж байгаа үр өгөөжтэй арга хэмжээ мөн байна. Гэсэн хэдий ч ард олны дундах цамын талаарх мэдээлэл хомс, судалгааны материал ч арвин бус байна. Тиймээс цам бүжгийн талаарх мэдлэг ойлголтыг ард олонд гүнзгий өгөх, учир мэдэхгүйгээс тухайн зан үйлд битүү сохроор хандан шүтэн бишрэхээс зайлсхийхүйд нөлөөлөх, ард олныг соён гэгээрүүлэх үйлсэд өчүүхэн ч болов нэмэр болох үүднээс энэ сэдвээр өгүүлэл бичлээ.

Цам. Цам бол шашны нарийн зан үйл, нөгөөтэйгүүр цамд гардаг зүйлс нь Бурханы шашны үзэл номлолыг баг, хувцас, өмсгөл, ая эгшиг, уран хөдөлгөөн төрөл бүрийн шашны эд зүйлсийн тусламжтайгаар таниулах театрчилсан үйл ажиллагаа гэж ойлгож болно. Цам нь тодорхой бэлтгэл сургууль, дэг хөдөлгөөн, цамнаж харайх байдал, баг, өмсгөлийн зүйл, хөгжмийн зэмсгүүд тэдгээрийн ая дан зэрэг олон зүйлийг цогцлоон байж сая бүрэн болдог. Цамын дүрүүд биеэрээ бурхадын дүр байдлыг үзүүлэн, биеийн уран нарийн хөдлөлийг харуулан цамнадаг ба бурхадын дүрд тоглож буй лам хүн сэтгэлдээ тухайн бурхан, сахиусаа бясалгаж байдаг. Цам нь хэлэнд үл харшилан үзэгч түмэнд шууд ойлгогддог учир бие, хэл, сэтгэл гурвын нэгдэл дээр бүрэлддэг гэж үзэж болох юм. Цам нь нэг талаас бурханы шашны зан үйл хэдий ч нөгөө талаас урлагийн нэгэн төрөл мөн. Цам нь анх Энэтхэгт үүсэн Төвдөд VII-VIII зууны үед дэлгэрсэн бөгөөд Монголд XVIII зууны үед орж ирэхдээ манай авьяаслаг уран гарт ард түмний сэтгэмж, гоо сайхны мэдрэмжээр бүтээгдсэн өвөрмөц онцлогтой хувцас, багтай төдийгүй манай Монголын үлгэр туульсын баатрууд, эртний бөө мөргөлийн уламжлалын зарим зүйлийг аван баяжиж Монгол хэлбэр төрхийг нэгэнт олж дэлхийн хаана ч байхгүй сонгодог, тансаг бүтээл болсон билээ¹.

Монголд цам маш түргэн хөгжиж, лам нар үндэсний зан үйл, нутгийн шүтээний тухай, домог зэргийг цамд оруулан баяжуулж, олон янзын агуулга, дүр байдал, үйл явдал, тавилт дэглэлтээр цамыг хөгжүүлсэн байна. Монголын 700 гаруй сүм хийдийн 500 гаруйд нь цам гардаг байсан тухай мэдээ бий. Цам хийд болгонд заавал байх шаардлагатай зан үйл биш бөгөөд тухайн хийдийн лам хувраг нарын бясалгалын түвшинтэй нь хамаатай зүйл юм. Нууц тарнийн ёс, бясалгал нь цам цамнаж болох хэмжээнд хүрсэн үед хийдүүд цамтай болдог гэж үздэг. Тэгэхлээр Монголын 700 гаруй сүм хийдийн 500 гаруй нь цам цамнадаг байсан гэвэл манай Монгол лам хуврага нар бясалгалын эрдэмд сайтар мэргэжсэн байсныг гэрчилж байна. Цамыг цамнах лам хүний жил нь таарсан, нохой, мэсийн сорвигүй, эрүүл чийрэг биетэй, сахил хүртсэн эрэгтэй лам цамнах учиртай байдаг. Дүр бүрийн онцлогоос хамаарч цоглог, хурдан шаламгай, эсвэл ихэмсэг алгуур хөдөлгөөнтэй хүнийг цамд тоглуулахаар сонгох ба Монголчуудын хүн шинждэг шалгууруудад тулгуурлан, нягт нямбай сонгон авна. Цамд залуу, чийрэг лам нарыг тоглуулдаг учир нь билэгдлийн утга бүхий гоёл чимэглэлтэй, хүнд баг хувцас өмсөн олон цагаар цамнахад хэр баргийн хүн дийлдэггүй, амархан цуцдагтай холбоотой байдаг. Дүр бүрт орлон тоглогч байна.

Эхэн үедээ цам зөвхөн тухайн хийд дотроо маш нууцлаг үйлдэгддэг бөгөөд ямар ч үзэгчгүй, зөвхөн сахил санваар хүртсэн лам нар оролцох эрхтэй, тодорхой зорилготой шашны зан үйл байжээ. Аажимдаа зан үйлийн дотоод агуулга, нууцлаг чанарыг лам нарын сахилтай хэсэг нь хадгалан үлдэж, том хурал хурах, лянга эвдэх, сор гаргах зэрэг нууц тарнийн ёсны үйлийг сүсэгтэн олны өмнө үйлддэг болж хийдээсээ гадагш гаран хүрээгээ тэлсэн. Үүний үр дүнд сүсэгтэн олон хүмүүний ертөнцөд залрах Бурханы шашныг

¹ Мөн тэнд 4-р тал

хамгаалагч Чойжин сахиус¹, Бурхад ямар дүртэйг харах боломжтой болсноор тухайн үедээ урлагийн үзмэрээр дутагдаж байсан энгийн хүмүүст ихээхэн таашаал эдлүүлж тэр хэрээрээ хийдүүдэд ч өргөл барьц ихээр цугларч өглөгийн эзэд олширсон байна.

Цамыг цамнахын зорилгыг Аяако тодорхойлохдоо: Нас барсан хүний сүнс дөчин есөн хоногийн дотор Бардо буюу зуурдын завсрын оронд байхдаа Бурхан, сахиус, чөтгөр, шулам зэрэг янз бүрийн юмтай таарах бөгөөд тэдгээрээс айж сүрдэлгүй, өөрийн шүтээнийг олж таних нь чухал байдаг учир хүн амьд байхдаа сахиус, догшидийг сайн таньж нүдэлж авахад цамын гол зорилго оршино гэжээ².

Цамыг наад зах нь 30-40, 70, 80, 100 хамгийн их хүний бүрэлдэхүүнтэй цам нь 300 гаруй хүнтэй байсан гэдэг. Монголд тавигдаж байсан цамуудаас Их хүрээ, Эрдэнэзуу, Амарбаясгалан, Заяийн хүрээ, Мандшир, Жанжин чойрын хүрээ, Ламын гэгээний хүрээ, Мөргөлийн хүрээ зэрэг томоохонд тооцогддог сүм хийдүүдийн цам ард олны хүндэтгэлийг хүлээж байсан байна.

Цамын утга учир нь хорон муу санаатныг зайлуулах, шидэт үйлдлийн аргаар шашны дайсныг устгах, хорвоо ертөнцөд шашныг бэхжүүлэн мандуулах явдал байдаг. Түүний агуулга нь бурханы шашныхаа ертөнцийг үзэх үзлийг илэрхийлдэг.

Цам нь бурханы шашинт Төвд, Монгол, Бутан, Хятад, Тува зэрэг олон оронд түгэн тархсан байдаг. Улс орон сүм хийд бүрийн шүтдэг сахиус, газар газрын эзэн савдаг өөр учир шашны зан үйл нь өвөрмөц, түүнийгээ дагаад бүжиг цам нь ч өөр өөрөөр боловсроход хүрсэн байна. Мөн цам цамнах өдөр, үргэлжлэх цаг хугацаа, үйлдэх зан үйл, цамчдын тоо, гарах дүрүүд нь харилцан адилгүй байдаг ч мөн чанараараа нэг, гагцхүү ямар бурхан, сахиус гарч цамнах, тэдгээрийн дараалал, тахил зэргийг өргөх цаг хугацаа нь өөр өөр болой³.

Молан тойны эхийн ачийг хариулсан гэх цам: Тус цамыг Монгол орны зарим сүм хийдэд дуулалт жүжгийн хэлбэрээр дуулж байжээ. Гэвч тэр нь Молан тойны эхийн ачийг хариулсан гэх судартай харьцуулвал харин тийм их өргөн хэмжээгээр дэлгэрч чадаагүй байжээ.

Нэг: Тус цамын цамналтад оролцох хүмүүс

Молан тойн: толгойдоо хашин хааны дүрийн баг зүүж, гартаа эрх барин, биедээ хүрэн торгон эмжээртэй торгон дээл өмсөөд дээгүүрээ орхимж гэдэргэсэн байдаг.

Молан хатан: Молан хатны амьд үеийн байдлыг цамнахдаа эмгэн цамын багийг толгойдоо зүүж, биедээ магнаг хуартай торгон дээл өмсөж цамнадаг. Үхээд сүнс нь чөтгөр болох үеийг цамнахдаа бяцхан бандийн хохимой толгойт багийг зүүлгэж, биедээ үхээрийн ясны зургийг хар буюу улаан өнгөөр зурсан цагаан хувцас өмсгөн цамнуулдаг.

Эрлэг хаан: Биедээ цойрчилын баг зүүж, цойрчилын хувцасыг өмсөн цамнадаг.

Бяцхан хохимой: Толгойдоо хохимойн багийг зүүж, биедээ цагаан хувцас өмсөн, гартаа гинж, эрэн шийдэм барьж цамнадаг. Ийм бяцхан чөтгөр хэд хэд байна.

Хоёр: Цамын агуулга

Эрт урьдын цагт Энэтхэгийн арван хааны улсад Хэрэунь гэдэг нэгэн баян байжээ. Тэр бол адуу мал нь тал дүүрэн, алт мөнгө эд эрдэнэс нь тоолоод барашгүй олон, улс гүрэндээ оройлсон баян байв. Тэрээр буян үйлдэн бясалгал хийж, лам хуврагийг хүндэтгэн, өглөг барьц сайн өгдөг сүсэг бишрэлтэй хүн аж. Тэрээр Лабуг-Эрдэнэ хэмээх ганц хүүтэй бөгөөд хүү нь ч эцэгтэйгээ адил бурхан ном, лам хуврагад сүсэг бишрэлтэй,

¹ Бурхад, догшид, лус савдгийн хүчийг өөртөө оршоож чаддаг онцгой увидастай шашныг хамгаалагч догшин сахиус

² Аяако.К, Монголын хүрээ цамыг бусад орны цамтай харьцуулан судалсан нь УБ., 1997

³ Позднеев А.М, Очерки быта Буддийских монастырей и буддийского духовенства в Монголии, Улан-Удэ., 2000

буян үйлдэн бясалгал хийж лам хуврагийг эцэг эхтэйгээ адил өргөн хүндэтгэж, хоол хүнс, хувцас хунар, эд мөнгийг харамгүй өргөдөг энэрэнгүй сэтгэлтэй, эерэг зантай хүн байв. Хэрэмүн баяны гоо үзэсгэлэнт залуу хатан нь харин эд мөнгөнд ховдог шунахай, бурхан номонд сүсэг бишрэлгүй лам хуврагийг өшөөтэй дайсан шиг ад үздэг хүн байлаа.

Гэнэт Хэрэмүн баян өвчнөөр нас барсанд Лабуг-Эрдэнэ эцгээ оршуулж лам хувраг залан ихэд буян ном үйлдээд хожим нь Лабуг-Эрдэнэ хүү арилжаа хийж зоос олъё гэж эхдээ хэлэн явахдаа: хүж зул өргөн, ном уншиж бурхан хуврагуудад идээ өргө. Өтгөсийг ихэд хүндэл, өчүүхэн багачуудыг асар, өдөр бүр буян хураа, үргэлжид ариун сүсэг сэтгэлийг үүсгэ хэмээн эхдээ захиад аян замдаа мордож гэнэ.

Молан хатан хүүтээ гадагш явсны хойно лам хувраг цугларч бурхан ном тахихыг миний чихэнд бүү сонсог, миний нүдэнд бүү үзэгдүүл хэмээн хараан зандарч бурхан тахилуудыг нь хураан хаяад, архи дарс уух, амтат идээ идэх мэтээр хүнд их нүглийг үйлдэн жаргаж суужээ.

Лабуг-Эрдэнэ хүү олон газраар удаан хугацаанд арилжаа наймаа хийн олз ашиг олоод гэртээ буцаж ирэв. Энэ үед Молан хатан бурхан номыг шүтэн буян үйлдэж байсан мэт аашилж байжээ. Гэвч айл хөршийнхөн нь "Молан хатан гурван эрдэнийг үл хүндлэн лам хуврагуудыг занчин, адуу малыг алж цаглашгүй их нүгэл үйлдэв" хэмээн хэлэв. Лабуг-Эрдэнэ энэ үгийг сонсоод ихээр зовж эхээсээ лавлан асуусанд Молан хатан "Энэ хүү харин эхдээ бас итгэхгүй болов" хэмээн уурлаж "Хэрэв би лам хуврагуудад муугаар хандсан бол долоо хоногийн дотор муугаар үхэж очир тамд унах болно" гэж амалжээ. Удсангүй Молан хатан өвчин олж долоо хоног дээрээ нас барав. Лабуг-Эрдэнэ хүү эхээ нас барсанд ихээр эмэгнэн гашуудаж хүүрийг нь оршуулаад буян үйлдэж зул хүж өргөв. Тэрээр үргэлжлүүлэн баян чинээлэг амьдралыг эдлэх дургүй болж эд эрдэнэс, адуу мал, гэр байшингаа лам хувраг ядуу ардуудад хуваан өгөөд Шахимунь бурхан дээр очиж бурханы номыг бясалган рид хувилгаан ихтэй арван шавийнх нь нэг болж нэрээ Молан тойн хэмээв. Сүүлээр нь Молан тойн төгс жаргалант диваажингийн оронд очиж, зол жаргалант амьдралыг эдлэж яваа эцэгтэйгээ уулзсан бөгөөд эхээ тамын оронд буй гэдгийг бас мэджээ. Тэр үүл хөлөглөн тамын оронд очиж халуун найман там, цусан балчиг там, хязгаарлашгүй тамаар тойрч эхээ эрсэн боловч олсонгүй. Эцэстээ эрж сурагласаар байгаад төмөр уул мэт үүд хаалгагүй аюуш тамд очиж өлөн чөтгөр болсон эхтэйгээ уулзав. Энэ тамд өдөр шөнийн ялгаа гэж байхгүй хайрах, түлэх, сүвэглэх, хутгалах тамыг амсаж хувхай мод мэт болсон Молан хатан өлсвөөс хайлсан ширэм ууж, өдөр шөнөдөө түмэнтээ үхэж түмэнтээ эдгэрдэг ажээ. Молан тойн идээг эхдээ барихад гал улаан болон хувилж гэдсэнд нь түймэр мэт шатав. Энэ байдлыг Молан тойн үзээд арга барж Арьяабал бурханы дээр очин эхээ аврахаар аврал асуужээ.

Арьяабал бурхан түүнд: "Чи эрдэмт бандида болсон боловч эхээ аварч чадахгүй. Олон хуврагыг залж их буян үйлд" гэв. Тэрээр Арьяабал бурханы зарлигаар 7-р сарын 15-нд дөрвөн зүг, найман зовхистын олон хуврагыг залж өглөг өгөн ерөөлийн хурал хийв. Буян их үйлдэж бясалгал сайн хийснээр Молан хатан очир тамын орноос гарч баян айлын шар өлөгчин нохой болон энэ орчлонд төржээ. Хожим нь номын хүчээр нохойн төрлөөс тонилоод хүний төрлийг олж бярмань охин болон заяаж, сүүлээр нь бурханы авралаар төгс жаргалант оронд баяр жаргалтайгаар амьдаржээ.

Молан тойны эхийн ачийг хариулсан гэх судар буюу үлгэр бол бурханы шашны хялбарчилсан зохиол. Монгол оронд түгээмэл дэлгэрсэн шашны уран зохиолын нэг

болно. Монгол хэлэн дээр энэ үлгэрийг 4-5 удаа орчуулж байсан бөгөөд Хөх хотын Гүүш Цоржийн орчуулгыг гурван удаа модон бараар хэвлэж байсан түүхтэй¹.

Эмгэн өвгөн цам: Нэг: Цамын баг ба хувцас хунар

Өвгөн цам бол цагаан сахал, хөмсөгтэй. Толгой дээрээ урт гэзгээ сул тавин, инээмсэглэсэн өвгөний дүрт багийг зүүдэг. Биедээ бор буюу хүрэн торгон дээл өмсөж, дээлийн гадуур зуны цагт торгон хүрэм, өвлийн цамд чоно буюу барын арьсан хүрэм өмсөж хүзүүндээ эрхи зүүж, торгон бүс бүслэн гартаа таяг тулна.

Эмгэн цам бол толгойдоо буурал урт гэзэгтэй, чихэндээ хоёр том сүйх / ээмэг / зүүж, нүүрэндээ атираатай, баярлангуй дүрт эмэгтэй хүний баг зүүж, гартаа таяг тулж цамнана. Цамын хөдлөл: Тус цамд ертөнцийн хүн төрөлхтний өсөх, өглөх, үхэх зэрэг амьдралын жам ёсыг дүрслэн цамнана.

Эмгэн өвгөн цам эхэлмэгц залуу үеийн дүр гаран инээх, туних дуугүйгээр үг ярилцах, хүн үзэхээс ичиж зовсон байдал гаргадаг бөгөөд хайр дурлалаа илтгэсэн янз маягаар хоёулаа зэрэгцэж цамнана.

Нас ахисан байдлыг дүрслэн цамнахдаа нэг нэгнээ муухай харах, хоёр зүг рүү хандан салж цамнах зэргийн үйлдлийг хийж, амьдралын явцдаа зөрчилдсөн байдлыг гаргана.

Өглөх үеийн дүрийг илтгэн цамнахдаа явж хөдлөх нь удаан, чих нь хатуураад нэгнийхээ үгийг сонсохгүй болсон байдлаар цамнаж байгаад таягтаа тээглэж унахад нөгөө нь түшиж босгох зэрэг шог дүрийг гарган цамнана.

Цамын төгсгөлд эмгэн өвгөн хоёулаа сүм хийдийн зүг мөргөх, залбирах, өглөг өгөх зэргийн хөдлөлийг хийж, буян номыг үйлдэж, бодь мөрийг олохоор хамт явж байгаагаа илтгэн цамаа төгсгөнө. Тус цамд Монгол орны ард түмний зан заншил, дүр байдлыг шог байдлаар үзүүлж цамнана. Энэ цамд ертөнцийн аливаа юм бүр өсөх, өглөх, мөхөх замаар явна гэсэн шарын шашны ёс учрыг тайлбарлажээ².

Ном зүй

1. Аяако К, Монголын хүрээ цамыг бусад орны цамтай харьцуулан судалсан нь, УБ., 1997 (Ph.D докторын зэрэг горилсон бүтээл. Улсын нийтийн номын сан, эрдэм шинжилгээний фонд).
2. Буддын шашин соёлын тайлбар толь, цуврал-I, II, УБ., 2000
3. Гангаа Д, Хүрээ цам, УБ., 2002
4. Дагвадорж Д, Бурханы Шашны Монгол уламжлал, УБ., 2002
5. Мягмарсамбуу Г, Шашныг хамгаалагч Догшин Чойжин, УБ., 2005
6. Нэргүй Ш, Хөтөч тайлбарлагч нарын мэдлэгийн санд, УБ., 2002
7. Позднеев А.М, Очерки быта Буддийских монастырей и буддийского духовенства в Монголии, Улан-Удэ., 2000
8. Цултем Н, Искусство Монголии с древнейших времён до начала XX века, Москва., 1984
9. Эрдэнэ С, Монгол цам, Өвөр Монгол., 1997

ABOUT BUDDHIST MASKED DANCING

The Buddhist knowledge is consisted of the ten sciences the major five and minor five. In the major five sciences have mechanical arts. And from the minor five sciences, one thing comes out which is named to be danced clearly. One of being danced clearly is masked Lamaist temple dance. One of the Buddhism activities is the dance. Why called it such like, the Buddhism be seen a winner, put down the enemies and the Buddhism activities are spreaded. The role of the masked dance is seen with appearance on Lamaism or gods. It is one of the Buddhism activities, but also is one sort of arts. When the masked Lamaism temple dance put into Mongolia from India and Tibet in XVIII century, it has been with specific dances by our talented and skilled Mongolian people. Also, in the specific Mongolian tsam can be danced some heroes on the folk-tales, worshipped ones and there are many tsam dancing in Mongolia with a lot of contents, appearance.

¹ Эрдэнэ С. Монгол цам Өвөр-Монгол., 1997 108-113-р тал
² Мөн тэнд 68-69-р тал